

**“ОРХОНЫ ХӨНДИЙД ХОТ БАЙГУУЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛД
ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДЭЭС ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТОВЬЁОГ**

Д/д	Санал ирүүлсэн байгууллага	Санал	Саналыг тусгасан байдал
1	Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан /2022.11.10-ны өдрийн ЗГ-2/581 тоот албан бичиг/	Орхоны хөндийд шинэ нийслэлийн байршлыг сонгож, техник эдийн засгийн үндэслэл, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, хотын орон зайн төлөвлөлтийг хийх саналуудыг дэмжиж байна.	Дэмжсэн
2	Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар. /2022.11.07-ны өдрийн 1/5657 тоот албан бичиг/	<p>Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсгийг үндэслэн “Орхоны хөндийд хот байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг баталж, тогтоолын төсөлд дараах саналтай байна.</p> <p>1. Тогтоолын төслийг Хот байгуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т дахь заалт буюу Улсын Их Хуралд шинээр хот байгуулах болон татан буулгах, нүүлгэн шилжүүлэх тухай шийдвэр гаргах бүрэн эрх олгосон заалтыг үндэслэх;</p> <p>2. Тогтоолын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 35, 36 дугаар зүйлд заасан Улсын Их Хурлын тогтоолын эх бичвэр, төслийн бүтцэд тавигдах шаардлагад нийцүүлэх;</p> <p>3. Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийж гүйцэтгэх шаардлагатай.</p>	<p>1. УИХ-ын тогтоолын төслийн үндэслэл хэсэгт Хот байгуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т дахь заалтыг нэмж тусгав.</p> <p>2. Хууль тогтоомжийн тухай хуулийн 35, 36 дугаар зүйлд заасан шаардлагад нийцүүлэн Улсын Их Хурлын тогтоолын эх бичвэр, төслийн бүтцийг боловсруулав.</p> <p>3. Хууль тогтоомжийн тухай хуульд заасан холбогдох судалгаа, үнэлгээ, тооцооллыг хийв.</p>
3	Сангийн сайд Б.Жавхлан. /2022.11.08-ны өдрийн 01/7657 тоот албан бичиг/	1.Тогтоолын төслийн 2 дахь заалтын 1-д “Орхоны хөндийд шинэ хот байгуулах газрын байршил, хэмжээг тогтоож, холбогдох хууль тогтоомжийн дагуу газрыг улсын тусгай хэрэгцээнд авах” гэж заасныг “Шинэ Хархорум хот байгуулах газрыг холбогдох хууль, журмын дагуу байршил, хэмжээ, заагийг тогтоож улсын	1. УИХ-аар тогтоол батлагдсаны дараа газрыг байршил, талбайн хэмжээг нарийвчлан судалж тогтоосны үндсэн улсын тусгай хэрэгцээнд авах арга хэмжээг Газрын тухай хуулийн 16.1.13, 18.1.2 дахь заалт болон Засгийн газрын 2017 оны 287 дугаар тогтоолоор баталсан “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ, заагийг

		<p>тусгай хэрэгцээнд авах” гэж өөрчлөх, Мөн Газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-т улсын тусгай хэрэгцээнд авахтай холбогдуулан газрыг солих буюу эргүүлэн авах тохиолдолд нөхөн олговор олгохоор зохицуулсан байдаг. Иймд газрыг тусгай хэрэгцээнд авсан тохиолдолд нөхөн олговрын асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар тогтоолын төсөлд тусгах</p> <p>2.Тогтоолын төслийн 2 дахь заалтын 3-т “Шинэ Хархорум хотыг байгуулах ажлыг удирдан зохион байгуулах байнгын бүтэц, тогтолцоог бий болгох, бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлах, түүнд шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсвийн болон санхүүжилтийн бусад эх үүсвэрээс төсөвлөн үе шаттайгаар хэрэгжүүлэх” гэснийг “Шинэ Хархорум хотыг байгуулах ажлыг удирдан зохион байгуулах байнгын бүтэц, тогтолцоог бий болгох, бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлах, түүнд шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсвийн болон санхүүжилтийн бусад эх үүсвэрээс шийдвэрлэх боломжийг судлах” гэж өөрчлөн найруулах</p> <p>3. Үзэл баримтлалын төсөлд: Хүн амыг нутаг дэвсгэртээ тэнцвэртэй нутагшуулан суурьшуулах, нийслэл Улаанбаатар хотос бусад хот сууриныг хөгжүүлэх шаардлагын хүрээнд Хархорм хүтын бүтээн байгуулалтын ажил нь Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусан “Шинэ Зуунмод”, “Майдар”, зэрэг шинэ хотууд, “Чингис хаан” олон улсын шинэ нисэх буудлыг түшиглэн байгуулах “Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс” зэрэг томоохон бүтээн байгуулалтын ажлуудтай хэрхэн уялдах, эрэмбэ дарааллын хувьд хэрхэн хэрэгжүүлэхийг тодруулах нь зүйтэй байна.</p>	<p>тогтоох, ашиглах журам”-ын дагуу шийдвэрлүүлэх бөгөөд үүнд нөхөн олговрын асуудал багтана.</p> <p>2. Уг тогтоолын төслийн 2 дахь заалтаар авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг УИХ-аас Засгийн газарт даалгаж байгаа тул 2 дахь заалтын 3-ыг саналын дагуу өөрчлөн найруулах шаардлагагүй юм.</p> <p>3. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Алсын хараа - 2050” баримт бичгийн 1 дүгээр хавсралтад тусгагдсан зорилт 8.2.-ын I үе шатны 8.2.3-т “Орхоны хөндийд шинэ нийслэлийн байршлыг сонгож, техник эдийн засгийн үндэслэл, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ” гэж, II үе шатны 8.2.3-т “Шинэ нийслэлд төрийн захиргааны болон зарим нийгмийн үйлчилгээний байгууллагуудыг үе шаттайгаар нүүлгэх ажлуудыг эхлүүлсэн байна”, III үе шатны 8.2.2-т “Шинэ нийслэлийг ЮНЕСКО-д бүртгэлтэй соёлын бүтээлч хот болгоно” гэж тусгасан. Мөн Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хавсралт 3.7.5-д “Орхоны хөндийд шинэ хотын суурьшлын бүсийн байршлыг судалж, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулна”, Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1 дүгээр хавсралт 3.6.6-д “Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан бүсчилсэн хөгжлийн бодлого, бүс нутгийн оновчтой бүтэц, хөгжлийн ирээдүйтэй сууринг тодорхойлж, орон зайн төлөвлөлтийг хийх” зорилтуудыг дэвшүүлэн хэрэгжүүлж байна. Иймд төрөөс баримталж буй бодлого, хөтөлбөрийн хүрээнд Орхоны хөндийд шинэ хот байгуулах асуудал нь “Шинэ Зуунмод”, “Майдар” зэрэг шинэ хотууд, “Чингис хаан” олон улсын шинэ нисэх буудлыг түшиглэн байгуулах “Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс” зэрэг томоохон бүтээн байгуулалтын ажлуудтай</p>
--	--	---	--

			уялдаж, эрэмбэлэгдсэн бөгөөд УИХ-ын тогтоол батлагдсаны дараа хэрэгжүүлэх үе шатны үйл ажиллагааг төлөвлөгөө гарган зохион байгуулна.
4	Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар. /2022.11.08-ны өдрийн 01/1335 тоот албан бичиг/	Танаас ирүүлсэн 1/5094 тоот “Орхоны хөндийд хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, үзэл баримтлалын төсөлтэй танилцлаа. Тус тогтоолын төслийг дэмжиж байна.	Дэмжсэн.
5	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан. /2022.11.10-ны өдрийн 01/2947 тоот албан бичиг/	Хот байгуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйл буюу Улсын Их Хурлын бүрэн эрх гэсэн зүйлийн 5.1.2 дахь заалтад “хотыг шинээр байгуулах болон татан буулгах, нүүлгэн шилжүүлэх тухй шийдвэр гаргах” гэж заасан тул “Орхоны хөндийд хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн тэмдэглэх хэсэгт Хот байгуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтыг нэмэх саналтай байна.	Саналын дагуу тогтоолын төсөлд “Хот байгуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт,...” гэж тусгав
6	Эрүүл мэндийн сайд С.Энхболд. /2022.11.09 ний өдрийн 1а/5084 тоот албан бичиг/	Тусгайлан өгөх саналгүй.	Тусгайлан өгөх саналгүй.
7	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б. Бат-эрдэнэ. /2022.11.08-ний өдрийн 01/6559 тоот албан бичиг/	1.Тогтоолын төслийн 2 дугаар зүйлийн 2-т “... зураг төслийг..” гэсний дараа “байгальд ээлтэй, ухаалаг хотын загвараар...” гэж нэмэх. 2.Орхоны хөндийд шинэ хот байгуулах газрын байршлыг тогтоохдоо Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомжид нийцүүлэх асуудлыг анхаарах.	1. Тогтоолын батлагдсан үзэл баримтлалын 2 дугаар бүлэгт “Монгол Улсын хүн амын нутагшилт суурьшлын оновчтой тогтолцоог бүрдүүлэх, бүс нутгийн тэнцвэрт хөгжлийг хангах, Нийслэл Улаанбаатар хотын хэт төвлөрөл, хүрээлэн буй орчны сөрөг нөлөөллийг бууруулах, түүхэн өв соёлыг хадгалан уламжлах, аялал жуулчлалыг дэлхийн түвшинд хүргэх зорилгоор уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, байгаль экологид ээлтэй ногоон, ухаалаг “Шинэ Хархорум хот”-ыг байгуулан хөгжүүлж, иргэдийг эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс “Орхоны хөндийд шинэ хот байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулна”, 3 дугаар бүлэгт Үндэсний соёл, иргэншлийн өв уламжлалыг хадгалсан, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангасан ногоон, ухаалаг шинэ хотыг байгуулах замаар Орхоны хөндийг

			<p>засаг захиргаа, түүх соёл, аялал жуулчлалын идэвх өндөр бүс болгож хөгжүүлнэ..</p> <p>2. Саналын дагуу Орхоны хөндийд шинэ хот байгуулах газрын байршлыг тогтоох асуудлыг Газрын тухай, Хот байгуулалтын тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд боловсруулна.</p>
8	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар. /2022.11.08-ний өдрийн 01/2910 тоот албан бичиг/	Тусгайлан өгөх саналгүй.	Тусгайлан өгөх саналгүй.
9	Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт. /2022.11.08-ний өдрийн 01/5138 тоот албан бичиг/	Тогтоолын төслийг дэмжиж байна	Дэмжсэн.
10	Соёлын сайд Ч.Номин.	Хууль тогтоомжийн хүрээнд тогтоосон хугацаанд санал ирүүлээгүй .	Санал ирүүлээгүй
11	Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн. /2022.11.08-ний өдрийн а/4281 тоот албан бичиг/	<p>1. “Орхоны хөндийд шинэ хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалын 1.2 дахь хэсэгт “... Орхоны хөндийд соёлын дурсгалт газрыг Дэлхийн өвийн жагсаалтад..” бүртгүүлсэн тухай дурдсан байх тул үзэл баримтлалын Гуравдугаар зүйл “Тогтоол батлагдсантай холбогдуулан үүсэх нийгэм, эдийн засгийн үр дагавар” хэсэгт эсхүл, Дөрөвдүгээр зүйл “... олон улсын гэрээ болон хууль тогтоомжийн талаар” хэсэгт 1972 онд батлагдсан “Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах конвенц”-тай холбогдуулан нэмэлт тайлбар оруулах.</p> <p>2. Улсын Их Хурлын тогтоолын төслийн үндэслэл хэсэгт дурдсан “Мянганы зам болон дэд бүтцийн босоо тэнхлэгийн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2001 оны 09 дүгээр тогтоол, “Бүсийн тулгуур төв хотыг тогтоох тухай” Улсын</p>	<p>1. Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсгийг үндэслэн “Орхоны хөндийд хот байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд, Барилга, хот байгуулалтын сайд нар хамтран баталсан.</p> <p>2. “Мянганы зам болон дэд бүтцийн босоо тэнхлэгийн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2001 оны 09 дүгээр тогтоол, “Бүсийн тулгуур төв хотыг тогтоох тухай” Улсын Их Хурлын 2003 оны 01 дүгээр тогтоолоор Өвөрхангай аймгийн төв Хар-Хорин хотыг Хангайн бүсийн тулгуур төв байхаар шийдвэрлэсэн. Иймд Орхоны хөндийд байгуулагдах хотын асуудлыг тус тогтоолтой нийцүүлэх, Мянганы замын хэвтээ тэнхлэг нь бүсийн тулгуур төв хотуудыг холбож, бүс нутгийн эдийн засгийн хөгжилд ихээхэн ач холбогдол бүхий</p>

		Их Хурлын 2003 оны 01 дүгээр тогтоолууд нь “Орхоны хөндийд хот байгуулах тухай” зорилттой уялдахгүй байх тул үндэслэл хэсгээс хасах, эсэхүүл “... тогтоолын төслийг боловсруулсан тухай танилцуулга”-д дээрх тогтоолуудыг үндэслэл болгосон шалтгааны тайлбар, тодруулгыг нэмж тусгуулах саналтай байна.	тэнхлэг тул Улсын Их Хурлын уг 2 тогтоолтой нийцүүлэх шаардлагатай болно.
12	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны дэд сайд Ч.Золбаяр. /2022.11.10.-ны өдрийн 03/1973 тоот албан бичиг/	Тогтоолын төслийн хоёрдугаар хэсгийн 2/ “Шинэ Хархорум хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө зам, тээвэр, эрчим хүч...” гэсний дараа “...харилцаа холбоо...” гэж нэмэх саналтай байна.	Тогтоолын төслийн хоёрдугаар хэсгийн 2-т “Шинэ Хархорум хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, зам, тээвэр, эрчим хүч, инженерийн дэд бүтцийн хангамжийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулах;” гэж заасан бөгөөд инженерийн дэд бүтэц гэдэгт холбоо мэдээлэл, ус хангамж, ариутгах татуурга, дулаан, инженерийн бэлтгэл арга хэмжээний асуудлууд багтсан болно. Зам, тээвэр, эрчим хүчний хангамжийн асуудлыг тэргүүн ээлжинд шийдвэрлэх шаардлагатай асуудлууд .
13	Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан. /2022.11.14-ний өдрийн 1а/5499 тоот албан бичиг/	Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Хот, хөдөөгийн сэргэлт”-ийн зорилтод “Зарим их дээд сургуулийг мэргэжлийн чиглэл, салбараар нь төрөлжүүлж, дагуулт хотууд болон орон нутагт хотхон байгуулан шилжүүлэх замаар хотын төвлөрлийг сааруулах” үйл ажиллагаа тусгагдсан тул Орхоны хөндийд шинэ нийслэлийн байршлыг сонгож, техник эдийн засгийн үндэслэл, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэхдээ тус асуудлыг анхаарч үзэхийг хүсье.	Орхоны хөндийд шинэ нийслэлийн байршлыг сонгож, техник эдийн засгийн үндэслэл, тооцоотой уялдуулан хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах явцад их дээд сургуулиудыг төлөвлөх асуудлыг холбогдох норм, нормативын хүрээнд шийдвэрлэгднэ.
14	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун. /2022.11.11-ний өдрийн 01/3564 тоот	“Орхоны хөндийд хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хууль тогтоомжийн төсөлд хамаарахгүй байх тул уг хуулийн 12.1 дэх хэсэгт заасан аргачлалын дагуу холбогдох судалгаа, үнэлгээг хийсний үндсэн дээр батлагдсан үзэл баримтлалын хүрээнд боловсруулан санал авах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн дагуу боловсруулав.

	албан бичиг/		
15	Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр. 2022.11.14-ний өдрийн 1а/4201 тоот албан бичиг	“Орхоны хөндийд хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, үзэл баримтлалтай танилцаад дэмжиж байна	Дэмжсэн.
16	Гадаад харилцааны дэд сайд Г.Амартүвшин. /2022.11.09-ний өдрийн 07/5893 тоот албан бичиг/	Зарчмын хувьд дэмжиж байна. Шинэ Хархорум хотыг ЮНЕСКО-ийн дэлхийн соёлын өвд бүртгэлтэй “Орхоны хөндийн соёлын дурсгалт газар”-ууд бүхий түүхэн ач холбогдолтой байршилд байгуулахаар төлөвлөж буй техник, эдийн засгийн үндэслэл, хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг боловсруулахаар тусгах нь зүйтэй гэж үзэж байна.	Орхоны хөндийд шинэ хот байгуулахтай холбоотой техник, эдийн засгийн үндэслэл, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад холбогдох хууль тогтоомж, норм дүрмийн дагуу боловсруулах бөгөөд саналд тусгагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ боловсруулагдах болно.
17	Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар /2022.11.08-ны өдрийн 01/87 тоот албан бичиг/	Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Алсын хараа - 2050” баримт бичгийн 1 дүгээр хавсралтад тусгагдсан зорилт 8.2.-ын I үе шатны 8.2.3-т “Орхоны хөндийд шинэ нийслэлийн байршлыг сонгох ...шинэ нийслэлд төрийн захиргааны болон зарим нийгмийн үйлчилгээний байгууллагуудыг үе шаттайгаар нүүлгэх” зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд боловсруулан ирүүлсэн “Орхоны хөндийд хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, үзэл баримтлалын төсөлтэй танилцлаа. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 20 дахь заалтад Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны даргын эрхлэх асуудалд “хотын төвлөрлийг сааруулах ... зохицуулалтын асуудал” хамаарахаар заасан. Энэхүү хуулийн зохицуулалт хүрээнд “Орхоны хөндийд шинэ хот байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг Монгол Улсын Сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны даргатай хамтран	Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсгийг үндэслэн “Орхоны хөндийд хот байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд, Барилга, хот байгуулалтын сайд нар хамтран баталсан. Улсын Их Хурлын тогтоолын төслийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн зорилтод нийцүүлэн хүн амын нутагшилт суурьшлын зохистой тогтолцоог бүрдүүлэх, хот, хөдөөгийн тэнцвэрт хөгжлийг хангах ...” гэж заасан нь төвлөрөл сааруулах бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэж байгаа тул өөрчлөн найруулах шаардлагагүй юм .

		батлах, Улсын Их Хурлын тогтоолын төслийн 1 дүгээр зүйлийг “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн зорилтод нийцүүлэн хүн амын нутагшилт суурьшлын зохистой тогтолцоог бүрдүүлэх, төвлөрөл сааруулах бодлогын хүрээнд хот, хөдөөгийн тэнцвэрт хөгжлийг хангах...” гэж өөрчлөн найруулах саналтай байгааг үүгээр хүргүүлж байна.	
18	Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга Б.Бат-Эрдэнэ. /2022.11.10-ны өдрийн 1/130 тоот албан бичиг/	Тусгайлан өгөх саналгүй.	Тусгайлан өгөх саналгүй.

---o0o---